



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Замын-Үүд сумын Засаг даргын тамгын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/35/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Сайншанд сум 2021 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: <a href="mailto:Gan-Ulziit@audit.gov.mn">Gan-Ulziit@audit.gov.mn</a> Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: <a href="mailto:Oyuntulkhuur.u@audit.gov.mn">Oyuntulkhuur.u@audit.gov.mn</a>  Аудитор: Ч.Хэрлэнчимэг Утас: 70523020 Цахим хаяг: <a href="mailto:Kherlenchimegch@audit.gov.mn">Kherlenchimegch@audit.gov.mn</a></p>
--------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХЧТАТ	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	14
3. Аудитын тайлан.....	15
3.1. Ерөнхий зүйл.....	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	16
3.4. Материаллаг байдал .....	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	18
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
3.9. Аудитын илрүүлэлт.....	19
Залруулсан алдаа.....	19
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	20
Аудитын зөвлөмж.....	21
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	21
4. Менежментийн захидал .....	22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	23

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

 <b>ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сайт: dornogovi@audit.gov.mn	<b>ЗАМЫН-ҮҮД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Б.БАТДУЛАМ ТАНАА</b>
2021.02.28 № 24/2021	
танай _____ -ны № _____ -т	
<b>Зөрчилгүй дүгнэлт</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p>	
<p>Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.</p>	
<b>Дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
<b>Бусад мэдээлэл</b>	
<p>Байгууллагын жилийн тайлан, санхүүгийн тайлан ба аудитын тайланд тусгагдсанаас бусад санхүүгийн ба санхүүгийн бус мэдээлэл байхгүй болно.</p>	
<b>Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага</b>	
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p>	
<p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.</p>	
<b>Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага</b>	
<p>Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг</p>	

буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>479,552,256.35</u></b>	<b><u>488,224,184.53</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	32,446,424.12	22,824,342.21
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	239,468.12	2,207,023.21
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	32,206,956.00	20,617,319.00
3351	Байгууллагаас авах авлага	32,206,956.00	20,617,319.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	00.00	400,000.00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	00.00	400,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	00.00	400,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	447,105,832.23	464,999,842.32
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	447,105,832.23	464,999,842.32
35410	Бичиг хэргийн материал	11,506,522.00	10,830,502.64
35420	Аж ахуйн материал	12,131,035.22	24,841,317.62
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	577,000.00	8,270,000.00
35450	Барилгын засварын материал	1,833,252.95	00.00
35470	Бусад хангамжийн материал	421,058,022.06	421,058,022.06
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,184,363,976.07</u></b>	<b><u>2,164,817,314.93</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,184,363,976.07	2,164,817,314.93
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,148,744,976.07	2,129,198,314.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,033,849,497.00	1,033,849,497.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-39,990,033.82	-64,188,425.02
39203	Авто-тээврийн хэрэгсэл	217,294,800.00	217,294,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-88,480,088.42	-101,085,950.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	143,970,497.02	156,337,409.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	-93,877,812.00	-94,367,971.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	86,337,489.30	79,949,284.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	-61,831,717.41	-60,355,052.20
39209	Зам, гүүрийн байгууламж	889,566,565.00	1,007,514,952.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-157,424,492.58	-232,287,951.44
39214	Бусад үндсэн хөрөнгө	315,645,406.00	315,645,406.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-96,315,134.02	-129,107,682.94
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	35,619,000.00	35,619,000.00
39301	Програм хангамж	2,044,500.00	2,044,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,044,500.00	-2,044,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	35,619,000.00	35,619,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,663,916,232.42</u></b>	<b><u>2,653,041,499.46</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>581,504.00</u></b>	<b><u>40,768,139.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	581,504.00	40,768,139.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	581,504.00	40,768,139.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	2,166,550.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	37,988,280.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	581,504.00	613,309.00
41361	Байгууллагад төлөх өглөг	309,254.00	341,059.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	272,250.00	272,250.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,663,334,728.42</u></b>	<b><u>2,612,273,360.46</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,663,334,728.42	2,612,273,360.46

**Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	476,930,039.18	476,930,039.18
51101	Өмч: - төрийн	476,930,039.18	476,930,039.18
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,544,545,683.90</b>	<b>1,493,484,315.94</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,544,545,683.90	1,544,545,683.90
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-51,061,367.96
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	641,859,005.34	641,859,005.34
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,663,916,232.42</u></b>	<b><u>2,653,041,499.46</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,591,967,146.00</b>	<b>1,939,141,267.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,707,438,146.00</b>	<b>129,500,717.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,260,882,323.00	4,055,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,260,882,323.00	4,055,600.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	446,555,823.00	125,445,117.00
122001	Хандив тусламж /дотоод/	446,555,823.00	125,445,117.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>884,529,000.00</b>	<b>1,809,640,550.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	963,187,450.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	963,187,450.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	884,529,000.00	846,453,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	884,529,000.00	846,453,100.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,274,957,861.91</b>	<b>1,990,202,634.96</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,096,602,031.35</b>	<b>1,990,202,634.96</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,044,081,412.71	1,979,965,967.96
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	520,005,427.00	608,114,127.30
210101	Үндсэн цалин	507,910,900.00	608,026,832.30
210105	Гэрээт ажлын хөлс	12,094,527.00	87,295.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	64,516,102.95	73,704,082.15
210201	Тэтгэврийн даатгал	44,286,021.95	53,440,205.15
210202	Тэтгэмжийн даатгал	4,455,285.00	5,045,813.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,593,707.00	3,717,881.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,016,461.00	1,203,681.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,164,628.00	10,296,502.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	53,189,428.36	63,167,221.98
210301	Гэрэл, цахилгаан	17,649,841.84	20,360,601.98
210302	Түлш, халаалт	32,348,528.52	42,613,120.00
210303	Цэвэр, бохир ус	3,191,058.00	193,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	91,039,221.32	62,261,500.44
210401	Бичиг хэрэг	26,965,206.00	20,069,354.94
210402	Тээвэр, шатахуун	38,243,840.00	23,333,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,314,435.00	7,547,087.50
210404	Ном, хэвлэл	355,000.00	5,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	969,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	731,551.00	10,262,658.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	17,709,189.32	74,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,194,110.00	00.00
210502	Хоол, хүнс	2,826,110.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	368,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,727,378.92	19,960,688.43
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	2,354,800.46
210602	Тавилга	584,560.00	1,321,591.82
210604	Урсгал засвар	9,142,818.92	16,284,296.15
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	15,179,900.00	6,829,400.00
210702	Дотоод албан томилолт	12,268,800.00	6,829,400.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,911,100.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	88,266,077.73	771,310,502.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87,483,117.73	770,268,382.80
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,000.00	650,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	237,960.00	172,620.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,400.00	175,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,600.00	44,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	198,963,766.43	374,618,444.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,534,333.02	204,893,789.00

**Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,269,000.00	2,440,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	160,160,433.41	167,284,655.86
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>52,520,618.64</b>	<b>10,236,667.00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>42,220,618.64</b>	<b>236,667.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>10,300,000.00</b>	<b>10,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,300,000.00	10,000,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,178,355,830.56</b>	<b>00.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,178,355,830.56</b>	<b>00.00</b>
220001	Барилга байгууламж	2,178,355,830.56	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>317,009,284.09</b>	<b>-51,061,367.96</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>6,231,371.38</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,231,371.38	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-6,231,371.38</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>310,777,912.71</b>	<b>-51,061,367.96</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>3,148,087,535.00</b>	<b>1,845,871,006.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,263,558,535.00</b>	<b>36,230,456.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,263,558,535.00	36,230,456.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,263,558,535.00	36,230,456.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,263,558,535.00	36,230,456.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>884,529,000.00</b>	<b>1,809,640,550.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	963,187,450.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	963,187,450.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	884,529,000.00	846,453,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	884,529,000.00	846,453,100.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>971,684,746.00</b>	<b>1,845,871,006.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>971,684,746.00</b>	<b>1,845,871,006.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>886,970,671.36</b>	<b>1,815,030,520.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	519,620,507.00	596,888,031.54
210101	Үндсэн цалин	421,047,561.00	467,806,692.51
210104	Урамшуулал	21,070,474.00	27,172,194.03
210105	Гэрээт ажлын хөлс	77,502,472.00	101,909,145.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	64,392,190.00	68,859,675.00
210201	Тэтгэврийн даатгал	44,162,109.00	51,255,013.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,455,285.00	5,963,721.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,593,707.00	4,770,977.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,016,461.00	624,542.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,164,628.00	6,245,422.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	53,189,428.36	25,178,941.98
210301	Гэрэл, цахилгаан	17,649,841.84	20,297,857.98
210302	Түлш, халаалт	32,348,528.52	4,624,840.00
210303	Цэвэр, бохир ус	3,191,058.00	256,244.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	70,128,384.00	52,279,093.48
210401	Бичиг хэрэг	12,093,728.00	11,408,454.98
210402	Тээвэр, шатахуун	32,603,000.00	22,408,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,314,435.00	7,589,087.50
210404	Ном, хэвлэл	15,987,200.00	7,662,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	960,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,410,021.00	2,250,851.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	368,000.00	306,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	368,000.00	306,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	17,968,070.00	28,899,646.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	22,242,700.00
210604	Урсгал засвар	12,968,070.00	6,656,946.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	17,264,640.00	6,829,400.00
210702	Дотоод албан томилолт	12,268,800.00	6,829,400.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,995,840.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	101,638,554.00	817,574,403.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,855,594.00	816,532,283.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,000.00	650,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	237,960.00	172,620.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,400.00	175,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,600.00	44,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	42,400,898.00	218,214,629.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,131,898.00	215,774,629.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,269,000.00	2,440,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>84,714,074.64</b>	<b>30,840,486.00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	74,414,074.64	20,840,486.00
<b>261090</b>	<b>Төвлөрүүлэх шилжүүлэг</b>	74,414,074.64	20,840,486.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	10,300,000.00	10,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,300,000.00	10,000,000.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>2,176,402,789.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,176,402,789.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,176,402,789.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,176,402,789.00	00.00
220001	Барилга байгууламж	2,176,402,789.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-2,176,402,789.00</u>	<u>00.00</u>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>441,311,039.18</b>	<b>322,774,563.60</b>	<b>148,567,376.89</b>	<b>912,652,979.67</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>441,311,039.18</b>	<b>322,774,563.60</b>	<b>148,567,376.89</b>	<b>912,652,979.67</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-6,949,669.82	-6,949,669.82
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>476,930,039.18</b>	<b>641,859,005.34</b>	<b>1,544,545,683.90</b>	<b>2,663,334,728.42</b>
D01	<b>2020 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>476,930,039.18</b>	<b>641,859,005.34</b>	<b>1,544,545,683.90</b>	<b>2,663,334,728.42</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>476,930,039.18</b>	<b>641,859,005.34</b>	<b>1,544,545,683.90</b>	<b>2,663,334,728.42</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-51,061,367.96	-51,061,367.96
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>476,930,039.18</b>	<b>641,859,005.34</b>	<b>1,493,484,315.94</b>	<b>2,612,273,360.46</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,016,363,000.00	846,216,433.00	170,146,567.00	83%
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,016,363,000.00	846,216,433.00	170,146,567.00	83%
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,006,363,000.00	836,216,433.00	170,146,567.00	83%
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	608,547,800.00	608,175,754.54	372,045.46	100%
210101	Үндсэн цалин	473,592,300.00	467,806,692.51	5,785,607.49	99%
210104	Урамшуулал	29,401,900.00	27,172,194.03	2,229,705.97	92%
210105	Гэрээт ажлын хөлс	105,553,600.00	113,196,868.00	-7,643,268.00	107%
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	85,957,600.00	68,859,675.00	17,097,925.00	80%
210201	Тэтгэврийн даатгал	61,336,700.00	51,255,013.00	10,081,687.00	84%
210202	Тэтгэмжийн даатгал	6,159,000.00	5,963,721.00	195,279.00	97%
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,922,800.00	4,770,977.00	151,823.00	97%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,229,200.00	624,542.00	604,658.00	51%
210205	Эрүүл мэндийн даатгал	12,309,900.00	6,245,422.00	6,064,478.00	51%
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	90,065,600.00	25,178,941.98	64,886,658.02	28%
210301	Гэрэл, цахилгаан	33,650,000.00	20,297,857.98	13,352,142.02	60%
210302	Түлш, халаалт	48,325,200.00	4,624,840.00	43,700,360.00	10%
210303	Цэвэр, бохир ус	8,090,400.00	256,244.00	7,834,156.00	3%
210304	Байрны түрээс	0	0	-	
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	63,189,300.00	50,197,593.48	12,991,706.52	79%
210401	Бичиг хэрэг	13,723,700.00	11,408,454.98	2,315,245.02	83%
210402	Тээвэр, шатахуун	20,830,800.00	20,814,000.00	16,800.00	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,611,200.00	7,101,587.50	8,509,612.50	45%
210404	Ном, хэвлэл	7,953,400.00	7,662,700.00	290,700.00	96%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	960,000.00	960,000.00	-	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,110,200.00	2,250,851.00	1,859,349.00	55%
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0	0	-	
2105	<b>Нормативт зардал</b>	368,000.00	306,700.00	61,300.00	83%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	368,000.00	306,700.00	61,300.00	83%
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	35,242,700.00	28,899,646.00	6,343,054.00	82%
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,242,700.00	22,242,700.00	-	100%
210604	Урсгал засвар	13,000,000.00	6,656,946.00	6,343,054.00	51%
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	3,568,700.00	3,029,400.00	539,300.00	85%
210702	Дотоод албан томилолт	3,568,700.00	3,029,400.00	539,300.00	85%
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	83,423,300.00	27,578,392.00	55,844,908.00	33%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	81,795,300.00	26,536,272.00	55,259,028.00	32%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	650,000.00	-	100%
210803	Даатгалын үйлчилгээ	240,000.00	172,620.00	67,380.00	72%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	650,000.00	175,500.00	474,500.00	27%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	44,000.00	44,000.00	50%
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	36000000	23990330	12,009,670.00	67%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,000,000.00	21,550,330.00	10,449,670.00	67%

**Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000,000.00	2,440,000.00	1,560,000.00	61%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	10000000	10000000	-	100%
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	0	0	-	
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	10,000,000.00	10,000,000.00	-	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,000,000.00	10,000,000.00	-	100%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,016,363,000.00	846,453,100.00	169,909,900.00	83%
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,014,363,000.00	846,453,100.00	167,909,900.00	83%
132001	Орон нутгийн төсвөөс	1,014,363,000.00	846,453,100.00	167,909,900.00	83%
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	2,000,000.00	0	2,000,000.00	0%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	0	2,000,000.00	0%

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /				
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>978,814,087.00</b>	<b>(978,814,087.00)</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	978,814,087.00	(978,814,087.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	978,814,087.00	(978,814,087.00)
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	2,081,500.00	(2,081,500.00)
210402	Тээвэр, шатахуун	0.00	1,594,000.00	(1,594,000.00)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	487,500.00	(487,500.00)
2107	Томилолт, зочны зардал	0.00	3,800,000.00	(3,800,000.00)
210702	Дотоод албан томилолт	0.00	3,800,000.00	(3,800,000.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	778,708,288.00	(778,708,288.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	778,708,288.00	(778,708,288.00)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	194,224,299.00	(194,224,299.00)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	194,224,299.00	(194,224,299.00)
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>0.00</b>	<b>999,417,906.00</b>	<b>(999,417,906.00)</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	999,417,906.00	(999,417,906.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	963,187,450.00	(963,187,450.00)
113	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	36,230,456.00	(36,230,456.00)
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Замын-Үүд сумын ЗДТГ-ын дарга Б.Батдулам танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд бараа материалын орлого болон зарцуулалтыг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа анхан шатны баримтат үндэслэх, бараа материалын гүйлгээг шууд зардалд тусгахгүй байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 22-ноос 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Хэрлэнчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Замын-Үүд сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын сарын 22-ны өдрийн 3/94 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Замын-Үүд сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нутаг дэвсгэрт төрийн бүх шатны бодлого зорилгыг зохион байгуулан хэрэгжүүлж, Засаг даргаас үйл ажиллагаагаа явуулах явуулах нөхцөлийг бүрдүүлэн мэргэжлийн зөвлөгөө дэмжлэгээр хангах,
- Нутаг дэвсгэрийн орон нутаг дахь байгууллагуудын салбар хоорондын уялдаа холбоог хангах, тэдгээр байгууллагуудыг бодлогын удирдамж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах,
- Нутаг дэвсгэрийн хөгжлийн урт дунд богино хугацааны бодлого боловсруулах,
- Орон нутгийн амьдралын тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэхийн зэрэгцээ биелэлтэд нь хяналт тавьж ажиллах,
- Төр, захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ явуулж, хяналт шалгалтын мөрөөр гүйцэтгэлийг сайжруулах,
- Төр, захиргааны байгууллагын бүтцийн өөрчлөлт, чиг үүрэг, үйл ажиллагаатай уялдсан хүний нөөцийн удирдлагын арга барилыг хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг үе шаттайгаар хангах замаар Тамгын газрыг мэргэшсэн тогтвортой, чадварлаг алба байлгахад анхаарах,
- Төрийн албан хаагчийн мэдлэг боловсрол, мэргэшлийн ур чадвар, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахтай холбогдсон төсөл, хөтөлбөрийг үе шаттайгаар боловсруулж хэрэгжүүлэх,

- Төрийн албан хаагчдыг авлигал, хээл хахуульд авталгүй үнэнч шударга, төрийн албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээг чанд сахиулж ажиллах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Замын-Үүд сумын ЗДТГ-ын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2020 онд Замын-Үүд сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2020 оны шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг байна.

Замын-Үүд сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “үр нөлөөтэй” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр жилийн төсвийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны нийт батлагдсан төсвийн 1,089,663.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 10,896.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон. Үүнийг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн. Учир нь батлагдсан төсвөөс гадна, тухайн байгууллагын нэмэлт санхүүжилтийн сумын онцгой комиссын үйл ажиллагаатай холбоотой санхүүжилтийг шилжүүлж, зарцуулсан байна. Нийт орлого болон зарлагын дүнд ЗДТГ-ын үйл ажиллагаа болон сумын онцгой комиссын үйд ажиллагаатай холбоотой орлого, зарлагыг тусгасан байна. Тиймээс 2020 оны 12 дугаар сард батлагдсан төсөв болох 1,016,363.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцож, 10,163.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тогтоов.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Замын-Үүд сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,671.9 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	32,446.4	22,824.3	9,622.1
Урьдчилгаа	-	400.0	-400.0

Бараа материал	447,105.8	464,999.8	-17,894.0
Үндсэн хөрөнгө	2,184,364.0	2,164,817.3	19,546.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,663,916.2</b>	<b>2,653,041.4</b>	<b>10,874.8</b>
Өр төлбөр	581.5	40,768.1	-40,186.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,663,334.7	2,612,273.3	51,061.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,663,916.2</b>	<b>2,653,041.4</b>	<b>10,874.8</b>

Авлага дансны үлдэгдэл 22,824.3 мянган төгрөг болж 9,622.1 мянган төгрөгөөр буурсан нь төвлөрүүлсэн нэмэлт санхүүжилтийн дансны авлага буурснаас шалтгаалжээ.

Нийт авлагын дүнд барагдах боломжгүй болон удаан жил болсон авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 464,999.8 мянган төгрөг болж 17,894.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд цар тахалтай холбоотойгоор зарцуулах шатахууныг худалдан авсан, мөн Монголын хаад, хатдын хөрөг зураг болон номыг 5,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан, малчдад худалдан борлуулах зориулалтаар өвс бэлтгэж, бараа материалын үлдэгдлээр тайлагнасан зэргээс шалтгаалжээ

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /үлдэгдэл өртгөөрөө/ 2,164,817.3 мянган төгрөг болж 19,546.7 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцож, анхны өртөг буурснаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 117,948.3 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 33,466.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 5,000.0 хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 4,654.5 мянган төгрөг, акталсан 22,832.7 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгийн үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна. Санхүүгийн программын ашиглах хугацаа дуусаж, хуримтлагдсан хасагдуулга нь анхны өртгөө бүрэн нөхсөн байна. Тус программ хангамжийг 2021 онд ашиглалтаас хасаж, санхүүгийн өөр программ хангамжийг ашиглах тухай тайлбарлав.

Өр төлбөр дансны үлдэгдэл 40,768.1 мянган төгрөг болж 40,186.6 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгаас авах санхүүжилт дутуу олгогдсоноос түлш халаалтын төлбөрийг бүрэн барагдуулаагүйгээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,612,273.3 мянган төгрөг болж 51,061.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 51,061.4 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж, үр дүн дансыг бууруулснаас шалтгаалжээ.

Замын-Үүд сумын ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,652,825.9 мянган төгрөгөөр буюу 54 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан дээд шатны байгууллагаас шилжүүлсэн эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 1,284,755.2 мянган төгрөгөөр буюу 61 хувиар өссөн буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хөрөнгийн зардал байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан гүйлгээ байхгүй байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,472,031.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,472,031.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 455,668.2 мянган төгрөгөөр бууруулж, 1,016,363.0 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төсөлд тусгагдсан зардлаас цалин, урамшууллын зардлыг 223,072.5 мянган төгрөгөөр, урсгал засварын зардал, баяр наадмын зардал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг материаллаг дүнгээр бууруулж баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,016,363.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,014,363.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 2,000.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 846,453.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого төвлөрүүлээгүй, ба нийт 846,453.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 846,216.4 мянган төгрөгийг зарцуулж 236.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 846,216.4 мянган төгрөг буюу 83.3 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 17,469.9 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 64,886.7 мянган төгрөгөөр, шуудан холбоо, бичиг хэргийн зардлыг 12,991.7 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 6,343.1 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөрийг 55,844.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 12,009.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан, мөн орон нутгийн төсвөөс 167,909.9 мянган төгрөгийн санхүүжилтийн дутуу авсан, мөн өөрийн орлого болох 2,000.0 мянган төгрөгийг төлөвлөгөөг биелүүлээгүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 4,037.0 мянган төгрөг, Онцгой байдлын газраас 273,770.5 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 721,610.4 мянган төгрөг, нийт 999,417.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээнд 778,708.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 194,224.3 мянган төгрөг, хангамж бараа материал болон томилолтын зардалд 5,881.5 мянган төгрөг, нийт 978,814.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 20,603.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуульд нийцээгүй орлогыг төвлөрүүлээгүй байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 133 мэдээллээс хугацаандаа оруулсан 110 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл, 19 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансны цахим системд байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулах тухай албан шаардлагыг хүргүүлэв.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 12,000.0 мянган төгрөгийн зөрчилд 12,000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлээгүй байна. Аудитаар өгсөн 900.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	1	12,000.0			1	12,000.0	0
Зөвлөмж	1	900.0	1	900.0	0	0	100
Нийт дүн	2	12,900.0	1	900.0	1	12,000.0	50

/мянган.төг/

Хэрэгжүүлээгүй албан шаардлагыг 2020 оны 5 дугаар сард аймгийн Прокурорын газарт шилжүүлсэн.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 157,879.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 154,035.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,543.8 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 300.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, үнийн дүнгүй 1 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Харилцагч байгууллагаас авсан үйлчилгээний төлбөрийг НББ-д бүртгэхдээ тооцооны дансанд тусгаагүй, үйлчилгээний төлбөрийг шилжүүлэхдээ шууд зардалд бүртгэсэн байна. Тайлант хугацаанд нийт 134,590.5 мянган төгрөгийн 207 гүйлгээг бүртгэсэн ба үүнийг аудитын явцад тооцооны дансанд тусгаж залруулсан.
2. Төсвийн гүйцэтгэлийн тайланд төсвийг тусгахдаа сумын ИТХ-аар батлагдсан төсвөөс 5,404.0 мянган төгрөгөөр орлого болон зарлагыг зөрүүтэй тусгасан байна. Уг алдааг аудитын явцад залруулж бүртгүүлэв.

3. Цалингийн бүртгэлийн шалгахад 9 дүгээр сард 2,250.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг олгохдоо авлагын дансанд тусгахгүйгээр шууд зардалд бүртгэсэн, мөн цалингийн өглөг дансанд бүртгээгүй, 7,8,9 дүгээр саруудад дундын санд шилжүүлэх 824.0 мянган төгрөгийг өглөг үүсгэсэн боловч, дахин өглөгийг бууруулж, зардал бууруулж бүртгэсэн. Албан хаагчдын 780.6 мянган төгрөгийн ХЧТА тэтгэмжийг албан хаагчдын дансанд шилжүүлэхдээ шууд зардалд тусгасан. Аудитын явцад нийт 6,170.1 мянган төгрөгийн алдааг залруулж бүртгэв.
4. Албан хаагчдын цалингаас суутгасан хуримтлалын мөнгийг хамтын сангийн дансанд шилжүүлээгүй боловч, үүнийг тайланд өглөгөөр тусгаагүй байна. Аудитын явцад хамтын санд шилжүүлбэл зохих 2,466.6 мянган төгрөгийг залруулж, өглөгөөр бүртгүүлэв.

### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 3,843.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 300.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 3,543.8 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

1. Цалингийн зардлаас 3,543.8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д *“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан журамд заасан эдийн засгийн ангиллыг зөрчиж, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлагыг хүргүүлэв.

2. Цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооллоор нийгмийн даатгалын шимтгэлд 610.6 мянган төгрөгийн авлагатай байхаар байтал тооцоо нийлсэн актаар 876.9 мянган төгрөгийн авлагатай, мөн албан хаагчдаас суутгасан шимтгэл нь нийгмийн даатгалын тайланд тусгасан шимтгэлийн дүнгээс нь 529.7 мянган төгрөгөөр зөрүүтэй, 6 болон 7 дугаар сарын нийгмийн даатгалын тайлан дахь эхний болон эцсийн үлдэгдэл 170.1 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Албан хаагчдын цалингаас суутгасан татварын өглөг авлагыг тооцож үзэхэд 1,596.4 мянган төгрөгийн авлагатай байх байтал тооцоо нийлсэн актаар 6,653.9 мянган төгрөгийн авлагыг бүртгэсэн байна. Үүнд сумын сонгуулийн хорооны ажилчдаас суутгасан татварын шилжүүлэг болох 3,552.0 мянган төгрөгийг тусгасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т *“санхүүгийн аливаа үйл ажиллагааг ...үнэн зөв бүртгэж, тайлагнах”* гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын шимтгэл болон ХХОАТ-ын тооцооллыг холбогдох байгууллагатай дахин хийж, үнэн зөв тайланг бэлтгэх албан шаардлагыг хүргүүлэв.

3. Шилэн дансны цахим системд 5.0 сая төгрөгөөс дээш нийт 138,520.3 мянган төгрөгийн 18 зардлын гүйлгээг шилэн дансны цахим системд мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5-д *“дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: ...цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”* гэж заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах тухай албан шаардлагыг хүргүүлэв.

4. Тайлант оны 7 дугаар сард 1 албан хаагчид олгосон 300.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг буцаан суутгаж аваагүй байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн

49 дүгээр зүйлийн 49.1-д “Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно”, гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалин хөлсийг буцаан суутгаж, орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн үнийн дүнгүй 1 алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Тухайн байгууллагын төсөвт сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын тогтоолоор өөрчлөлт оруулсан боловч, санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,000.0 мянган төгрөгөөр дутуу тусгаж, баталсан байна.

Төсвийн хэлбэлзэлд тухайн байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаанаас бүрдүүлэх орлогыг 5,404.0 мянган төгрөгөөр, зарим зардлыг нийт дүнгээр 5,404.0 мянган төгрөгөөр батлагдсан төсвөөс илүү тусгасан байна.

Замын-Үүд сумын ЗДТГ-ын төлөвлөгөөнд туслах болон үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэх орлогын төлөвлөгөөг 2019 оны тус сумын ИТХ-ын тогтоолд 2,000.0 мянган төгрөгөөр баталсан ба үүнийг бүрдүүлээгүй, орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байна. Иймд цаашид орлого бүрдүүлэх боломж, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, үндэслэлтэй тооцооллыг хийж, төсөвт тусгах шаардлагатай байна.

Иймд дээрх зөрчлийг төсвийн төвлөрүүлэн захирагчийн болон төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудитаар анхаарч, тайлбар тодруулга авах нь зүйтэй гэж үзэв.

#### 4. Менежментийн захидал

---

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал*

- 1.1. Илрүүлэлт: Нийт 24,896.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан 31 гүйлгээг шууд зардлаар бүртгэсэн байна.
- 1.2. Эрсдэл: Бараа материалын үлдэгдэл болон зардал буруу илэрхийлэгдэх.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан тушаалын 1 дүгээр хавсралтын 4.21-д заасны дагуу худалдан авсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг бараа материалын дансанд бүртгэж, анхан шатны баримтыг үндэслэн зарлагаар бүртгэж байх.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Замын-Үүд сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2021			ДГА-2021/35/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Замын-Үүд сумын ЗДТГ</b>		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Цалингийн урьдчилгааг олгоод суутгаагүй	300.0	Төлбөрийн акт	Тамгын газрын дарга, нягтлан бодогч	Б.Батдулам, Н.Тунгалаг
2	Шилэн дансны системд 138,520.3 мянган төгрөгийн 18 гүйлгээг байршуулаагүй	-	Албан шаардлага		
3	Зардлыг зориулалт бусаар зарцуулсан	3,543.8	Албан шаардлага		
4	НДШ, ХХОАТ-ын тайланд тусгагдан цалин хөлс болон суутгалын дүн зөрүүтэй	-	Албан шаардлага		
5	Нийт 24,896.2 мянган төгрөгийн бараа материалын гүйлгээг анхан шатны баримтат үндэслэн бүртгээгүй, орлого, бараа материалыг бүртгэхгүйгээр шууд зардалд тусгасан	-	Зөвлөмж		
6	Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсвийг зөрүүтэй тусгасан	10,808.0	Аудитын явцад залруулсан		
7	Хамтын санд шилжүүлэх хуримтлалыг албан хаагчдаас суутгаж авсан боловч, шилжүүлээгүй ба үүнийг тайланд өглөгөөр бүртгээгүй байна	2,466.6			
8	Цалингийн урьдчилгаа болон цалингаас суутгасан хамтын сангийн мөнгийг НББ-д буруу тусгасан.	6,170.1			
9	Харилцагч байгууллагаас үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг шилжүүлэхдээ шууд зардалд тусгасан, тооцооны дансанд бүртгээгүй байна.	134,590.5			
<b>ДҮН</b>		<b>157,879.0</b>			